

Уул уурхайн салбарын гэрээ

Профессор Ч. Хашчулуун (PhD)

МУИС, Эдийн засгийн тэнхим

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

1. Судалгааны танилцуулга

Судалгааны зорилго

- Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээний олон улсын туршлагуудыг харьцуулах
- Уул уурхайн компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах Монголын хууль эрх зүй, бодлогын хүрээг судлах

Монголд

- Нийт 35 гэрээ
 - Ихэнх нь орон нутгийн түвшинд
 - Ашигт малтмалын хуулийн 42.1 заалтаар, тусгай зөвшөөрөл эзэмшигч нутгийн захиргааны байгууллагатай заавал гэрээ байгуулах ёстой.
- 15 стратегийн орд. Үүнээс:
 - Оюу толгойн зэсийн гэрээ (амжилттай байгуулагдсан, төрийн хувь эзэмшилтэй)
 - МАК зэсийн гэрээ (амжилттай байгуулагдсан, төрийн хувь эзэмшилгүй)
 - Таван толгойн нүүрсний гэрээ (урьдчилсан шатанд цуцлагдсан)

Анхаарах асуудлууд

- ГШХО-д хөрөнгө оруулалтын гэрээ чухал нөлөө үзүүлдэг
- Уул уурхайн салбарын онцлог
- Монголын эдийн засагт уул уурхайн салбарын ач холбогдол
- Гэрээ бол эзэн орон хүртэх ашгаа нэмэгдүүлэх нэг арга
- Гадаадын хөрөнгө оруулагч Монголын Засгийн газартай томоохон (стратегийн) хөрөнгө оруулалтын гэрээ хийхэд харгалздаг өвөрмөц онцлогууд
- УИХ-ын тогтоолоор хэлэлцээрийн ерөнхий хүрээг тодорхойлдог

Анхаарах асуудлууд

- Эзэн орны хүртэх үр өгөөжийг баталгаажуулах: анхаарах асуудлууд, олон улсын туршлага
- Гэрээ хийх хүндрэлүүд: тэгш бус мэдээлэл
- Макро эдийн засгийн үр өгөөжийг тооцох
- Засгийн газарт гэрээний үр өгөөжийг үнэлэх чадавх сул байдаг нь үл итгэлцлийг үүсгэж, хэлэлцээрийг хүндрүүлдэг.
- Хөгжиж буй оронд ямар гэрээ илүү өгөөжтэй вэ?
- Хөрөнгө оруулагч талд ямар гэрээ илүү ашигтай вэ?

2. Эзэн орны хүртэх үр өгөөжийг НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Төсвийн орлогоор дамжуулж үр өгөөж хүртэх

- Татварын хувь, нөөц ашигласны төлбөрийн төрлийг хууль журмаар тогтоодог боловч компаниуд их хэмжээтэй, урт хугацаатай хөрөнгө оруулахдаа татварын орчныг тогтвортой байлгахыг хүсдэг
- Дэлхий даяар маш олон уул уурхайн төслүүд хөрөнгө оруулалт татахын тулд хоорондоо өрсөлдөж байдаг учраас хэт бага биш боловч өрсөлдөхүйц татварын түвшнийг санал болгох шаардлагатай
- Ашигт малтмалын үнэ байнга савлаж байдаг учир хоёр талын хүртэх үр өгөөж явцын дунд өсөж, буурч болно. Гэрээнд хэн илүү давуу талтай байх нь хэлэлцээрийн үед түүхийн эдийн үнийн мөчлөг ямар үе шатандаа байснаас хамаардаг
- Уул уурхайн салбарын тухайн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, тус салбарын талаарх олон нийтийн болон засгийн газрын ойлголт, хандлагыг харгалзан үзэх шаардлагатай.

Төсвийн орлогоор дамжуулж үр өгөөж хүртэх

- **Нөөц ашигласны төлбөр (Royalty):** Компаниуд нөхөн сэргээгдэхгүй нөөц олборлосныхоо төлөө улсын, эсвэл орон нутгийн төсөвт нэмэлт төлбөр төлөх ёстой.
- АМНАТ-ын хамгийн түгээмэл хэлбэр нь борлуулалтын орлогод суурилсан рояалти. **Олон улсын жишиг үнийг** баримтлах нь хялбар.
- АМНАТ-ын бусад хэлбэр:
 - АНУ-ын Невада, Аризона мужид ихэнх ашигт малтмал АМНАТ-гүй
 - Канадын Саскатчеванд цэвэр ашгийн 5%.
 - Чилид цэвэр ашгийн 5 – 14%, Перуд 1 - 6.28%
 - Лаост борлуулалтын нийт орлогын 1 - 7%
 - Австралид борлуулалтын нийт орлогод, хүдэр-7.5%, баяжмал-5%, металл-2.5%
 - Монголд борлуулалтын нийт орлогын 5%.
 - Үнэ өсвөл нэмэгдэнэ, боловсруулбал буурна.
 - Алтны АМНАТ - 2.5%

Төсвийн орлогоор дамжуулж үр өгөөж хүртэх

- **Компанийн орлогын татвар:** Бусад бизнестэй адил цэвэр ашгаас татвар төлнө. Дэлхий даяар татварын хувь буурч байгаа, одоогоор 25 – 35%. Гэрээнд тусгах зүйлс:
 - Хөрөнгө элэгдүүлэх хурд
 - Алдагдал шилжүүлэх жил – ихэнх улсад 5 - 7 жил. Монголд 4-8 жил
 - Ring fencing - компанийн уул уурхайн нэг төслөөс орох орлого, хасагдах зардлуудыг нөгөө төслийн орлого, зарлагаас бүрэн тусгаарлах.
- **Суутган татвар:** Зээлдүүлэгчид төлөх хүү, эздэд төлөх ногдол ашиг, туслан гүйцэтгэгч болон зөвлөхөд төлөх үйлчилгээний төлбөрт 5-10% татвар.
- **Бусад:** НӨАТ, импортын татвар, түүхий эдийн экспортын татвар, орон нутгийн татвар, газрын/лицензийн төлбөр, бусад хураамж, бүтээгдэхүүн хуваах
- Эдгээр татварыг тухайн үеийн хуульд заасан түвшнээр тогтворжуулах уу, эсвэл өөрөөр тогтоох уу, тусгайлсан хөнгөлөлт үзүүлэх үү гэдэг нь хэлэлцээрээс хамаарна.

Засгийн газар хувь эзэмших

- Засгийн газар төсөлд хувь эзэмших - төслийн менежментэд оролцох, ТУЗ-д суудалтай болох, ноогдол ашиг авах
- Төслөөс хүртэх үр ашиг нэмэгдэж, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө буурна гэж ихэнх хүмүүс боддог
- Гэхдээ хувь эзэмших нь сул талтай:
 - Хувьцаагаа зарж капиталын хожоо олох боломж бага
 - ТУЗ-ийн шийдвэр гаргалтад бодит нөлөө бараг үгүй
 - Хөрөнгө оруулагчид засгийн газрыг ирээдүйн ноогдол ашгаар нь барьцаалж болзошгүй
- Хувь эзэмших эсэхийг санхүүгийн нарийн загвар ашиглан зардал, үр өгөөжийг бодитой харьцуулж тогтоох шаардлагатай

Орон нутгаас бараа, үйлчилгээ худалдан авах

- Уул уурхайн компанийн зардлын $\sim 50\%$ нь бараа, үйлчилгээний худалдан авалт байдаг.
- Олон улсын компанитай гэрээ байгуулбал дотоодын бараа, үйлчилгээний чанар, стандарт сайжирч, үйл ажиллагаа өргөжин, өрсөлдөх чадвар сайжирна \rightarrow Ажил эрхлэлт, иргэдийн амьжиргаа сайжирна \rightarrow Уул уурхайн хамаарлыг бууруулах боломж үүснэ.

Дэд бүтэц хөгжүүлэх

- Уул уурхайн бүтээн байгуулалтын зардлын 40-80%-ыг дэд бүтцийн зардал эзэлдэг.
- Уул уурхайн дэд бүтэц эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хөгжлийг хурдасгадаг
- Дэд бүтэц эдийн засагт ямар нөлөө үзүүлэх нь түүний ашиглалтаас хамаардаг. Дэд бүтцийг хамтран ашигласнаар эдийн засгийн хувьд ашигтай боломжууд үүсдэг.
- Уурхайн гэрээ байгуулахдаа дэд бүтцийг нь хамтарч ашиглах олон талын төлөвлөгөө, судалгаа хийх шаардлагатай
- **Жишээ нь:** Liberia-Putu (2010) гэрээнд цахилгаан, усан хангамж, төмөр зам, усан боомтыг хэрхэн хамтарч ашиглахыг нарийвчлан тусгасан

Ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх

- Уул уурхайн компанид олон хүн ажиллах → дотоодын ажиллах хүчний мэргэжлийн ур чадвар, туршлага нэмэгдэнэ → иргэдийн орлого, амьжиргаа дээшилнэ.
- Дунджаар компанийн зардлын 16% нь ажилчдын цалинд зарцуулагддаг.
- Уурхайн ажиллах хүчинд дотоодын ажилчдын эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл болон сургалтын талаар хөрөнгө оруулалтын гэрээнд нарийвчлан тусгах шаардлагатай
- **Жишээ:** Либери улс мэргэжлийн чадвар шаардагдахгүй ажлын байранд зөвхөн дотоодын иргэн ажиллуулахыг шаарддаг. Дотоодын иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах замаар эхний 5 жилд техникийн, удирдлага менежментийн орон тооны 30%-ийг дотоодын иргэдээр, 10 жилд 70%-ийг дотоодын иргэдээр бүрдүүлэх, лиценз авахаас өмнө болон дараа уул уурхайн чиглэлээр суралцах оюутнуудад заасан хэмжээгээр тэтгэлэг олгох

Орон нутгийн оролцоог хангах

- Хэлэлцээрийн явцад орон нутаг идэвхтэй оролцох ёстой
- Олон улсын байгууллагуудын тогтоосон стандартууд:
 - НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн Тусгай төлөөлөгчийн газраас гаргасан Хариуцлагатай Гэрээний Зарчмууд
 - Тухайн төсөлд шууд ба шууд бусаар өртөх орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх
 - Тэдгээр иргэдийг олж тодорхойлох, ямар хэмжээтэй нөлөөлөлд хэрхэн өртөж байгааг гүнзгийрүүлэн шинжлэх
- Жишээ:
 - Конго улс Kolwezi төсөл – мэдээллийг орон нутгийн иргэдэд радио болон утасны мессежээр франц, свахили хэл дээр хүргэдэг
 - Гватемалын Glamis төсөл – орон нутгийн иргэдтэй хамтарсан зөвлөл байгуулсан

Нийгмийн болон байгаль орчны асуудлууд

I. Газар

- Уурхай ашиглалтаас үүдсэн нүүлгэн шилжүүлэлт нь нийгмийн тогтвортой байдалд эрсдэлтэй
- Түгээмэл ашигладаг стандартууд: IFC-ийн Тогтвортой байдлын хүрээ (Стандарт 5), EBRD-ийн Байгаль орчин, нийгмийн бодлого (10 шаардлага)

II. Эмзэг бүлэг

- Уугуул иргэд, эмэгтэйчүүд гэх мэт тодорхой бүлгүүд илүү эмзэг байдаг
- IFC-ийн Стандарт 7-д сөрөг нөлөөг аль болох багасгах, уугуул иргэдийн хүний эрх, нэр төр, соёлыг дээдлэх, соёлын хувьд тохирох арга замаар хөгжлийн үр шимийг нэмэгдүүлэх бизнесийн үйл ажиллагаа явуулахыг заасан

III. Ус

- Усны ашиглалт, ус бохирдох эрсдэл бол нийтлэг тулгардаг асуудал
- Компаниуд боловсруулах шатанд усыг дахин ашиглах, ууршилтыг багасгах замаар усны алдагдлыг бууруулах, ус ховор нутагт усны ашиглалтыг аль болох бууруулах, ус цэвэрлэх байгууламжид хөрөнгө оруулах шаардлагатай

3. Хөрөнгө оруулалтын гэрээ: Монголын жишээ

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнөх гадаадын хөрөнгө оруулалтын туршлага

- Эдийн засгийг 1948 оноос төлөвлөгөөний дагуу хөгжүүлж эхэлсэн. 1951-1990 онд 8 удаагийн 5 жилийн төлөвлөгөө хэрэгжүүлсэн.
- Эхний төлөвлөгөөнд эдийн засгийг ХАА, аж үйлдвэр хосолсон бүтэцтэй болгох, 1960 оноос хойш аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх
 - Дархан хот байгуулагдсан (1961)
 - Бүтээмжийг дээшлүүлэх, хөдөө аж ахуйг механикжуулах, хөдөө орон нутгийг эрчим хүчээр хангах, Чойбалсан хотыг хөгжүүлэх (1966)
 - Хивс, арьс ширний салбарыг хөгжүүлэх, биотехнологийн суурийг тавих, мах, хүнсний үйлдвэрүүдийг (1971)
 - Бүх салбарт чанарыг дээшлүүлэх, уул уурхай, хүнд аж үйлдвэр хөгжүүлэх (1976)
 - Сүүний салбарыг хөгжүүлж, орчин үеийн ХАА фермүүд байгуулах, экспортын шинэ салбар болох ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх (1986)

Зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө гадаадын хөрөнгө оруулалт татаж байсан Монголын туршлага

- Эдийн засаг жижиг, хүн ам цөөн, малаас өөр хөрөнгө хомс тул том хөрөнгө оруулалт хийх бэрхшээлтэй.
- 1962 он хүртэл ЗХУ болон БНХАУ-ын хөрөнгө оруулалтыг ашигладаг байсан
- 1962 онд ЭЗХТЗ (СЭВ-СМЕА)-ийн гишүүн болсноор хөрөнгө оруулалт хийх, зээл авах, хамтарсан үйлдвэр байгуулах боломжтой болсон
 - Хамгийн том нь Монгол-ЗХУ-ын уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет нэгдэл, УБ төмөр зам
 - Бусад төсөл голчлон зээл, тусламж хэлбэрээр санхүүжилт авсан, өмчлөл нь 100% Монголд.
- Засгийн газар хоорондын эдгээр хамтарсан төслүүд өнөөгийн “мега төслүүдийн” эхний хэлбэр.
 - Хөрөнгө оруулалт нь төлөвлөгөөний дагуу хийгдэнэ
 - Үйл ажиллагааг нь улс хоорондын гэрээгээр зохицуулна
 - Хувьцаат компанийн засаглалаар биш, хамтарсан үйлдвэрийн зөвлөлөөр дамжуулж удирдана

Зах зээлд шилжих үеийн гадаадын хөрөнгө оруулалт

- 1993 оны ГШХО-ын хууль: гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн суурь болсон, төрийн ямар байгууллагууд ГШХО-ыг удирдаж, дэмжихийг заасан
- Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (FIFTA) байгуулагдав.
- Гэхдээ 2000 он хүртэл ач холбогдол бага байсан. Оёдол нэхмэлээс өөр салбарт ГШХО бараг байгаагүй
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ амжилтгүй болсон

Уул уурхайн хөрөнгө оруулалтад нөлөөлсөн гол хуулиуд

- 1993 оны ГШХО хуульд шүүхээр маргаан шийдэх заалтыг оруулсан
- 1997 оны Ашигт малтмалын хуульд тогтворжуулалтын гэрээний талаар заасан (5 жил, 2 сая ам.долларын босго)
- 2002 онд ГШХО-ын хуульд хөрөнгө оруулалтын гэрээний тухай болон тогтвортой байдлын гэрээний заалтууд нэмэгдсэн
- 2002 оны заалтаар, тогтворжуулалтын гэрээ бүх салбарын ГШХО-д хамаарах бөгөөд Сангийн яамтай гэрээ байгуулна
- АМХ-ийн 33-т зааснаар байгаль хамгаалах, дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргаатай гэрээ байгуулна
- 2012 оны Стратегийн салбарын гадаадын хөрөнгө оруулалтын хууль
- 2013 оны Хөрөнгө оруулалтын хууль

Уул уурхайн салбар дахь үндэсний эрх ашгийг тодорхойлох

- 2006-2008 оны Үндэсний хөгжлийн цогц бодлого
- 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Уул уурхайн том төслүүд үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгүүр гэх ерөнхий хандлага
- Хамаарах дэд бүтэц
- Ажиллах хүчний асуудал
- Татвар, нөөц ашигласны төлбөрийг нэн тэргүүнд тавих
- Сүүлд нэмэгдсэн: орон нутгаас худалдан авалт хийх
- Сүүлийн үед анхаарал татаж буй: уурхай дагасан хот байгуулах, орон нутагтай гэрээ хийх, нийгмийн үйлчилгээ, түүх дурсгал, экологи, усны асуудлууд
- Холбогдох бодлогын баримт бичгүүд (2014): нэмүү өртөг бий болгох ерөнхий хүрээ

Уул уурхайн том төслүүдэд бэлтгэх

- 2002 оны ГШХО-ын хууль том хөрөнгө оруулалтын төслүүдийг татах гол заалтуудыг тусгасан. Тухайлбал:
 - Хариуцах хөрөнгө оруулалтын агентлаг
 - Хөрөнгө оруулалтын гэрээний тодорхойлолт
 - Тогтворжуулалтын гэрээний үндсэн зарчим
 - Хувь эзэмшигчээр оролцох боломж, хөрөнгө оруулалтыг гадаадын шүүх дээр хамгаалах боломж
- 2006 оны АМХ-д стратегийн ордуудыг тодорхойлсон
 - 5.4-р зүйлд ордууд дахь Засгийн газрын хувь эзэмшлийг заасан

Өмчлөлийн талаарх заалтыг дагалдсан бодлогын шийдвэрүүд

- АМХ-д хувь эзэмшлийн санхүүжилтийг зааснаар улсын гадаад өрийг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймээс:
 - Улсын өрийн удирдлага, өрийн хязгаар, Төсвийн тогтвортой байдлын хууль
 - Төсвийн тухай хуулиар төсвийн харилцааг ерөнхийд нь удирдах
 - Өрийн удирдлагын тухай хууль
- Холбогдох дэд бүтэц (хэрэв хөрөнгө оруулагч санхүүжүүлэх бол) нь бас тусгай эрх зүйн зохицуулалт шаардана.
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, Концессын хууль
- Төрийн томоохон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх (Хөгжлийн банкны тухай хууль)
- Орон нутгийн хөгжилд тусгайлан анхаарах (Орон нутгийн хөгжлийн сан байгуулах), АМХ-д нутгийн удирдлагатай гэрээ байгуулах заалт нэмэх

3.2. Оюу толгойн гэрээ

Оюу толгойн гэрээг үнэлэх нь

- Оюу Толгойн гэрээ (2009, 2011, 2015) нь Монголын хамгийн том, олон нийтэд нээлттэй ганц гэрээ.
- Олон улсын судалгаануудад Оюу толгойн гэрээг ил тод байдлаараа “сайн” гэж үнэлдэг.
- Уг гэрээ маш олон асуудлыг харгалзаж үзсэн, гэрээний загвар боловсруулах жишээ болгож авах боломжтой
- Гэрээний давуу болон сул талуудыг задлан шинжлэх нь дараагийн гэрээнүүдэд ямар заалт тусгах шаардлагатай, ер нь Монголын уул уурхайн салбар болон институцийн орчинд ямар өөрчлөлт шаардлагатай байгааг тодорхойлоход тус дөхөм болно

Оюу толгойн татварын тогтворжуулалт

- **ААНОАТ:**
 - Татвар ноогдох орлогын 25%
 - Алдагдлыг дараагийн 8 хүртэлх жилээр шилжүүлэх
 - Хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцох
- **АМНАТ** буюу рояалти: нийт орлогын 5%, татвар ноогдох орлогоос хасна
- **НӨАТ:** Импортолсон, боловсруулсан, худалдсан бараа, гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд 10%
- **Суутган татвар:** зээлийн хүү, баталгааны төлбөр, рояалтигийн орлого, санхүүгийн түрээсийн орлого, удирдлагын зардал болон менежментийн үйлчилгээний төлбөр, түрээсийн төлбөрт 20%
- **Бусад татвар:** ноогдол ашиг, рояалти, хүүгийн орлогод 10%, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод 2%, эрх шилжүүлсэн орлогод 30%

Оюу толгой ХХК-ийн төлсөн татвар

Хүснэгт 1. Оюу толгойн төлсөн татвар, сая ам.доллар

Он	ААН ОАТ	АМНАТ	Бусад татвар, хураамж	Улсын нийт	Орон нутгийн татвар, хураамж	Ажил олгогчийн шимтгэл	Бусад төлбөр	Орон нутгий н нийт	Нийт
2010	0	0	95	95	0	0	0	0	95
2011	0	0	366	366	0	6	10	16	382
2012	0	0	244	244	0	18	4	22	266
2013	0	4	175	179	0	20	21	41	220
2014	16	46	95	157	0	16	12	28	185
2015	66	111	74	251	9	13	5	27	278
2016	67	39	43	149	9	14	43	66	215
2017	0	54	76	130	8	16	74	98	228
Нийт	149	254	1168	1571	26	103	169	298	1869

Эх сурвалж: Рио Тинто, жилийн тайлангууд

- Гэрээ байгуулагдсанаас хойш Оюу толгой төсөл 1,869 сая долларыг улсын ба орон нутгийн төсөвт төлжээ.
- 2013 оноос өмнө уурхайн эхний шатны хөрөнгө оруулалт эрчимтэй хийгдсэн учир НӨАТ, гаалийн татвар гол хувь нэмэр оруулж байсан бол ил уурхайн олборлолт эхэлснээр ААНОАТ болон АМНАТ (рояалти) гол хэсгийг бүрдүүлэх болсон.

Оюу толгойн татварын тогтворжуулалт

- Монголын нэгдэж орсон давхар татварын гэрээ маргаан дагуулдаг
- Татварын ерөнхий хуулиар, хэрвээ Монгол Улсын нэгдэж орсон гэрээн дэх татварын хувь Хөрөнгө оруулалтын гэрээнд (2009) заасан хувиас ялгаатай бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.
- Гэрээнд суутган татвар 20% гэж заасан. Гэвч Нидерланд улстай байгуулсан давхар татварын гэрээгээр, Оюу толгой компани Оуи Tolgoi Netherland B.V. охин компанид шилжүүлсэн зээлийн хүүгийн төлбөрөөс Монголын Засгийн газар 10% суутган татвар л авч байна.
- 2011-2015 онд Монголын засгийн газар 232 сая ам.долларын суутган татварын орлого авч чадаагүй (SOMO, 2018).

Оюу толгойн өмчлөл дэх төрийн оролцоо ба санхүүжилт

- Гэрээний эхний 30 жилд Монголын Засгийн газар Оюу толгой ХХК-ийн 34%-ийг эзэмших ба дараагийн 20 жилд энэ хувийг 50% хүртэл өсгөх боломжтой.
- Гэвч Засгийн газар өөрийн 34%-д ноогдох хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагч талаас зээлж авсан. Хувь эзэмшил ба санхүүжилтийн энэ тохиролцоо засгийн газрын хүртэх үр өгөөжид том нөлөө үзүүлж, гэрээний хамгийн төвөгтэй асуудал болоод байна.
- Хэрэв алт, зэсийн үнэ удаан хугацаанд доогуур байвал Засгийн газар төсөл хаагдахаас өмнө ноогдол ашиг авч чадахгүй ч байж болно.
- Мөн Засгийн газрын авсан зээлийн хүү нэлээд өндөр: Эхлээд 9.9% + АНУ-ны инфляц байсан бол 2011 онд 6.5% + LIBOR хүү болсон.

Оюу толгой орон нутгаас бараа, үйлчилгээ худалдан авах

- ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээнд бараа, үйлчилгээг орон нутгаас худалдан авах талаар дэлгэрэнгүй тусгаагүй.
- Гэхдээ орон нутгаас бараа, үйлчилгээ худалдан авахыг дэмжсэн агуулгатай 2 заалт орсон:
 - Хөрөнгө оруулагч дотоодын болон импортын аль ч барааг худалдан авахдаа ялгаварлахгүй, адил хэмжээний татвар төлнө.
 - ОТ төсөлд бараа үйлчилгээ нийлүүлэх орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд туслах зорилготой хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- **Компанийн тайланд дурдсанаар, 2017 онд бүх бараа, үйлчилгээний 83%-ийг дотоодоос худалдан авсан.**

Оюу толгойн дэд бүтэц

- Гэрээнд дэд бүтцийн талаар иж бүрэн тусгахыг зорьсон боловч дэд бүтцийг тойрсон олон асуудал тодорхойгүй, хэт ерөнхий томъёологдсон.
- **Хэрэгжилт:**
 - Усан хангамжийн сүлжээ, нисэх буудал баригдсан, авто болон төмөр зам, цахилгаан станцын асуудал шийдэгдээгүй
 - Жишээ нь, Өмнийн бүсийн эрчим хүчний салбарын хамтын ажиллагааны гэрээ хэрэгжээгүй

Оюу толгойн хөдөлмөрийн харилцаа

- Гэрээнд ажил эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэх заалтууд нэлээд дэлгэрэнгүй туссан.
 - Төсөлд ажиллах монгол ажилчдын сургах, чадавхжуулах үүрэг хариуцлагыг тодорхой заасан
- 2018 оны 2-р улирлын байдлаар, төслийн ~15,000 ажиллагсдын 93% нь монголчууд
- 2010 оноос хойш гадаад, дотоодын их, дээд сургуулийн 260 оюутанд сургалтын тэтгэлэг олгосон
- Гэхдээ зарим заалтын үр дүнг хэмжихэд учир дутагдалтай

Оюу толгойн орон нутгийн оролцоо

- Гэрээнд АМХ-д заасны дагуу орон нутгийн захиргаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулна гэж тусгасан
- Оюу толгой ХХК болон Өмнөговь аймаг, түншлэгч сумдын хоорондын хамтын ажиллагааны гэрээг 2015 оны 4-р сард байгуулсан
 - Орон нутгийн дэвшүүлсэн төсөл, хөтөлбөрийг дэмжихэд зориулан Хөгжлийг Дэмжих Санд жил бүр 5 сая ам.доллар төвлөрүүлдэг
 - Харилцааны хороо нь орон нутгийн саналыг нэгтгэж, Хөгжлийг дэмжих сангийн удирдах зөвлөлд зөвлөмж өгнө

Оюу толгой дахь нийгмийн болон байгаль орчны асуудал

- Нийгмийн асуудал
 - Гэрээнд эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөрийн талаар дурдаагүй. Гэхдээ Рио Тинто жендерийн тэгш байдлыг дэмжих, уул уурхай дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхээ илэрхийлсэн
 - 2017 оны байдлаар Оюу толгойн ажиллах хүчний 24% нь эмэгтэйчүүд
- Байгаль орчны асуудал
 - Төслийн нөлөөлөлд өртсөн малчдын гомдлыг Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорацийн дэргэдэх Эрх зүйн хяналт Зөвлөгөө Омбудсмэний газар (ЭЗХЗОГ) хүлээн авч шийдвэрлэдэг
 - 2017 оны 5 сард талууд энэ асуудлаар тохиролцоонд хүрч, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Хэрэгжилтийг нь ЭЗХЗОГ хянан.
 - Гэрээнд ус ашиглалтын талаа тодорхой тусгасан

4. CONNEX санаачилга

CONNEX-ийн түүх

- UNCTAD-ын Хөрөнгө оруулалтын судалгааны газар хөгжиж буй орнуудад гадаадын хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийхэд туслах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээнд туслах алба (ICAF) байгуулахыг санал болгосон (1999)
- Монровиагийн тунхаглал (2013)
 - Мэдээлэл хуваалцах, зохицуулах механизм
 - Гэрээний хэлэлцээрийг дэмжих төв
 - Шуурхай зөвлөгөө өгөх нэгж
- 2014 оны “Их долоо”-гийн уулзалтаар CONNEX санаачилгыг эхлүүлсэн
 - “Хөгжиж буй түнш орнуудад олборлох салбарын иж бүрэн арилжааны гэрээ байгуулах, хэлэлцээр хийхэд нь өргөн хүрээтэй, тодорхой мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх”

CONNEX-ийн түүх

- 2016 оны “Их долоо”-гийн уулзалтаар CONNEX санаачилгыг хэрэгжүүлэх, хүчин чармайлтаа нэмэгдүүлэхээ дахин илэрхийлсэн
- 2015-2017 онд Германы Засгийн газар, ЭЗХХАБ (OECD) хамтран Хэлэлцээрийг дэмжих форум (NSF)-ыг байгуулсан.
- 2016 оны 9 сард “Их долоогийн” CONNEX санаачилгын олон улсын хурлын үеэр CONNEX-ийг Дэмжих алба байгуулсныг зарласан.
 - “Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд хүсэлт гаргавал зөвхөн хүсэлт гаргасан засгийн газрын эрх ашгийг урьтал болгож, том хэмжээтэй иж бүрэн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад нь туслана”

CONNEX-ийн Дэмжих алба

- Аль нэг бүс нутгийг онцлохгүй; газар зүйн аль бүсийн хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд тусламж, дэмжлэг хүсэж болно
- Уул уурхайн томоохон төслийн хэлэлцээрийн шатанд явж байгаа, дахин хэлэлцээр хийж байгаа, эсвэл хэлэлцээр хийх бэлтгэл хангаж байгаа аль ч шатанд дэмжлэг хүсэж болно
- Эхний ээлжид уул уурхайн салбарын том хэмжээтэй, иж бүрэн хөрөнгө оруулалтын гэрээний тусламжийг үзүүлнэ.
- ISLP, ALSF, OECS, IGF, NEPAD Agency гэх мэт олон санаачилга, хамтын ажиллагаатай уялдаатай ажиллахаар төлөвлөсөн
- Хуульч, санхүүч, бизнесийн стратегич, эдийн засагч, байгаль орчны мэргэжилтэн, орон нутгийн хөгжлийн мэргэжилтэн, геологич, уул уурхайн инженер гэх мэт төслийн хэлэлцээрт шаардагдах экспертүүдээр хангана
- Дэмжлэгийн төрөл, хэмжээ, агуулгыг тухайн нөхцөл байдалтай уялдуулна. Тухайн нөхцөлд тохирсон богино хугацааны дэмжлэгээс эхлээд хэлэлцээрт чиглэсэн урт хугацааны дэмжлэг үзүүлэх боломжтой
- Бүх дэмжлэг туслалаа үнэ төлбөргүй
- Хүсэлт хүлээж авснаас хойш аль болох богино хугацаанд дэмжлэг үзүүлнэ

Цаашид анхаарах асуудлууд

- Definition of large project as compared to the legally established strategic mine issue
- Having all stakeholders' consensus
- Integrated form of agreement, integrated project delivery platform
- The spillovers from the main mining project to infrastructure, social issues and regional development, all governed by different laws, require unified approach which is not clear now
- The importance of having an integrated agreement and unified management

Анхаарал хандуулсанд баярлалаа !